



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/473

Мөрөн сум

Эхийн эндэгдлийг хэлэлцэх зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1,66.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/550 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эхийн эндэгдэл гарсан тохиолдлын холбогдох баримтуудыг нягтлан судалж, нотолгоонд тулгуурлан орон нутгийн түвшинд эхийн эндэгдлийг дахин гаргахгүй ажиллах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох шийдвэр гаргах чиг үүрэг бүхий зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: Эрүүл мэндийн газрын дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого, үйл ажиллагаа зохион байгуулах мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн захирал

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эмгэг судлаач их эмч

Эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Шаардлагатай тохиолдолд аймгийн бусад ерөнхий мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн газрын Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

6711011303

2.

2. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Зөвлөлийн дарга (Д.Түвшинбаяр) - д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор Засаг даргын 2018 оны А/352 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Цэцэгмаа)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН